

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, их өгөгдөлд суурилсан хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээлэл бүрдүүлэх, солилцох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулж, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж

2.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“ажил” гэж аливаа хүн ихэвчлэн цалин хөлс, орлого олох зорилгоор биеийн болон оюуны хүч чадамжийг ашиглан хийдэг үйл ажиллагааг;

3.1.2.“ажилгүй хүн” гэж хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг;

3.1.3.“ажил хайгч” гэж ажилгүй, ажилтай боловч үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон, эсхүл карьераа ахиулах, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор өөр ажил хайж байгаа, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагад бүртгүүлсэн хүнийг;

3.1.4.“ажил хийхэд бэлэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалд заасан тухайн хугацаанд, эсвэл тухайн хугацаанаас хойш ажил хийхэд бэлэн байхыг;

3.1.5.“ажил идэвхтэй хайж байгаа хүн” гэж хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалд заасан хугацаанд цалин хөлс, орлого олох зорилгоор ажлын байрны талаар мэдээлэл авах, ажил хайх зар байршуулах, хөдөлмөр

эрхлэлтийн үйлчилгээний байгууллага, ажил олгогчид хандах зэргээр ажил хайх оролдлого хийсэн ажил хайгчийг;

3.1.6.“ажил олгогч” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

3.1.7.“бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1.1-д заасан аж ахуйн нэгж байгуулан ажиллуулж байгаа иргэнийг;

3.1.8.“байнгын ажил” гэж 6 ба түүнээс дээш сарын хугацаанд үргэлжлэн хийгдэх, дуусах хугацаа нь урьдчилан тогтоогдоогүй ажлыг;

3.1.9.“түр ажил” гэж 6 сараас ихгүй хугацаанд хийж гүйцэтгэх, эсхүл түр зуурын зорилгоор гүйцэтгэх ажлыг;

3.1.10.“кейс менежмент” гэж зорилтот бүлгийн хүний хөдөлмөр эрхлэлт дэх саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн хүн тус бүрээр тухайлсан төлөвлөгөө гаргаж ажиллах хүн төвтэй үйлчилгээ үзүүлэх аргачлалыг;

3.1.10.“зохистой хөдөлмөр эрхлэлт” гэж хангалттай орлого, цалин хөлстэй, нийгмийн хамгааллын баталгаа хангагдсан, адил тэгш хөдөлмөр эрхлэх нөхцөлтэй, баталгаатай, бүтээмжтэй, хөдөлмөр эрхлэхийг;

3.1.11.“хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого” гэж ажилд зуучлах, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэлтийг дэмжих зэргээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг;

3.1.12.“хөдөлмөр эрхлэлтийн байгууллага” гэж хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагыг.

4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим

4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.үл ялгаварлах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах;
- 4.1.2.хүртээмжтэй, дэвшилтэт технологид суурилсан байх;
- 4.1.3.албадан хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байх;
- 4.1.4.эдийн засаг, нийгмийн бодлоготой нийцүүлж, салбар, бүс, орон нутгийн хамтын ажиллагаа, төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан байх;
- 4.1.5.ногоон эдийн засаг, асрахуйн эдийн засаг, халамжаас хөдөлмөрт шилжих, идэвхтэй насжилтын бодлогыг дэмжихэд чиглэсэн байх;
- 4.1.6. ил тод, нээлттэй, судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл

5.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа дараах төрөлтэй байна:

- 5.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;
- 5.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ.

5.2.Ажилгүй иргэн, ажил хайгч, ажил олгогчийн хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 5.2.1.хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах;
- 5.2.2.хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх, хувийн төлөвлөгөө боловсруулах;
- 5.2.3.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх;
- 5.2.4.хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулах;
- 5.2.5.ажилд зуучлах;
- 5.2.6.ажилгүйдлийн тэтгэмж олгох;
- 5.2.7.Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан туршилтын болон бусад үйлчилгээ.

5.3.Ажилгүй иргэн, ажил хайгч, ажил олгогчийн хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 5.3.1.мэргэжлийн сургалт зохион байгуулах;
- 5.3.2.олон нийтийн ажил зохион байгуулах;
- 5.3.3.дагалдан ажилтныг дэмжих;
- 5.3.4.ажил олгогч, аж ахуй эрхлэгчийг дэмжих;
- 5.3.5.Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын болон бусад арга хэмжээ.

5.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэнээс шууд болон шууд бус хэлбэрээр төлбөр авах, цалин хөлснөөс суутгахыг хориглоно.

5.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь бага насны хүүхэд асарч байгаа эх, эцэг, байнгын асаргаатай хүн асарч байгаа иргэн /асрахуйн хөдөлмөр эрхэлж байгаа иргэн/, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, хорихоос суллагдсан иргэн, мэргэжил болон ажлын туршлагагүй иргэн, ажлын туршлага нь тасалдсан иргэн /урт хугацааны ажилгүйчүүд/, асрамжийн газраас хөдөлмөрийн насанд хүрээд гарсан иргэн, архи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодисын хамааралтай иргэн, гадаадад урт хугацаагаар ажиллаж амьдарч байгаад эх орондоо эргэн ирсэн иргэн зэрэг зорилтот бүлгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хөдөлмөрийн нөөцийг бүрэн ашиглаж, ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

5.6. Зорилтот бүлгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг шаардлагатай үед кейс менежментийн аргачлалыг ашиглан хэрэгжүүлнэ.

5.7.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

Нэгдүгээр дэд бүлэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

6 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах

6.1.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь иргэн, ажил олгогч, хөдөлмөрийн зах зээлд оролцогч талуудыг дараах мэдээллээр хангана:

- 6.1.1.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдал, чиг хандлага;
- 6.1.2.ажлын байрны захиалга, цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн харилцааны бусад мэдээлэл;
- 6.1.3.ажил мэргэжлийн стандарт, ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт, мэргэшлийн түвшин;
- 6.1.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

6.1.5.нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдсан хөдөлмөр эрхлэлтийн бусад холбогдох мэдээлэл.

7 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх, хувийн төлөвлөгөө боловсруулах

7.1.Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ нь ажил хайгч, ажилгүй иргэний талаар мэдээлэл цуглуулах, хөдөлмөр эрхлэх чадварыг нь үнэлэх, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломжийг тодорхойлж дүгнэлт гаргах үйлчилгээнээс бүрдэнэ.

7.2. Ажил хайгч, ажилгүй иргэний хүсэлтэд үндэслэн хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийнэ.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан үнэлгээнд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн тохирох үйлчилгээг тодорхойлно.

7.4.Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх аргачлал, заавар, маягтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.5.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтан хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ болон иргэний хүсэлтийг үндэслэн хамтран боловсруулна.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасан төлөвлөгөөг хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийснээс хойш ажлын 10 хоногийн дотор боловсруулна.

7.7.Ажил хайгч, ажилгүй иргэн хувийн төлөвлөгөөг зөвшөөрч баталснаар хэрэгжүүлж эхэлнэ.

7.8.Хувийн төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээс хойш 3 сарын хугацаанд ажил хайгч, ажилгүй иргэн ажилд зуучлагдаагүй бол хувийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулна.

8 дугаар зүйл.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх

8.1.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд ажил, мэргэжлийн ойлголт, тодорхойлолтын талаарх мэдээллээр хангах, тохирох ажил, мэргэжлийн оношилгоо хийж тодорхойлох, ажлын байртай танилцуулах, ажил мэргэжлийн өсөлт хөгжлийг удирдан зохицуулахад зөвлөн туслах үйлчилгээ хамаарна.

8.2.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалтын хэлбэрээр үзүүлж болно.

8.3.Хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хамтран ажиллана.

8.4.Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад үзүүлэх үйлчилгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажилгүй иргэн, насанд хүрэгчдэд үзүүлэх үйлчилгээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэх бодлогын чиглэлийг баримтална.

8.5.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг холбогдох мэргэжлийн байгууллага, зөвлөхөөр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

9 дүгээр зүйл.Хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулах

9.1.Хөдөлмөрт бэлтгэх сургалтад ажлын байрны зөөлөн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход туслах, ажлын байранд өөрийгөө бэлтгэх зэрэг үйлчилгээ хамаарна.

9.2.Хөдөлмөрт бэлтгэх сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага, зөвлөхийн оролцоог хангаж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, хэрэгжүүлнэ.

9.3.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулах үйлчилгээг мэргэжлийн байгууллага, зөвлөхөөр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

9.4.Мэргэжлийн байгууллага, зөвлөх энэ хуулийн 9.2-т заасан хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулна.

10 дугаар зүйл.Ажилд зуучлах

10.1.Ажилд зуучлах үйлчилгээнд ажил хайж байгаа иргэнд хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олоход, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээ хамаарна.

10.2.Ажилд зуучлагдсан иргэний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажил олгогчтой эргэх холбоотой хамтран ажиллана.

10.3.Хөдөлмөрийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага тус хуулийн 5.1.1-т заасан үйлчилгээнд цагийн ажил хийх хүсэлтэй ажил хайгч, ажилгүй иргэнийг нэгэн адил хамруулна.

Хоёрдугаар дэд бүлэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

11 дүгээр зүйл.Мэргэжлийн ур чадварын сургалт зохион байгуулах

11.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ажилгүй иргэн, ажил хайгчийг мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах богино хугацааны сургалтад хамруулна.

11.2.Мэргэжлийн ур чадварын сургалтыг мэргэжлийн онцлогоос шалтгаалан ажлын байранд, зайнаас, танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж болно.

11.3.Мэргэжлийн ур чадварын сургалт зөөлөн ур чадварын сургалттай хосолсон байна.

11.4.Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллага мэргэжлийн ур чадварын сургалтыг мэргэжлийн боловсролын байгууллага, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

11.5.Сургалтын зардлыг төрөөс бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлнэ.

11.6.Сургалтын хугацаанд иргэнд хоол, унааны зардал олгож болно.

11.7.Иргэдийн хүсэлтэд тулгуурлан өмнө эзэмшсэн мэдлэг, ур чадвараа үнэлүүлэх, мэргэшлийн түвшин тогтоолгох тохиолдолд гарах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэсэгчлэн санхүүжүүлнэ.

11.8.Чадамжийн үнэлгээ, шалгалт зохион байгуулж, шаардлага хангасан иргэнд чадамжийн гэрчилгээ олгоно.

11.9.Сургалтын чанар, үр дүнгийн хяналт, үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар тогтмол хийлгэнэ.

12 дугаар зүйл.Олон нийтийн ажил зохион байгуулах

12.1.Олон нийтийн ажил нь тусгай мэргэжил эсвэл мэргэжлийн бэлтгэл шаардагдахгүйгээр хийх цалин хөлстэй ажлыг хэлнэ.

12.2.Олон нийтийн ажлыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах, зам, нийгмийн дэд бүтцийн тохижилт, арчилгааны чиглэлээр зохион байгуулна.

12.3.Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллага нь тухайн орон нутгийн засаг захиргааны нэгж, ашгийн бус байгууллага (*цаашид олон нийтийн ажлыг зохион байгуулагч гэх*)-тай олон нийтийн ажлыг зохион байгуулах зорилгоор гэрээ байгуулна.

12.4.Гэрээнд ажлын төрөл, ажиллах хугацаа, байрлал, хамрагдах хүний тоо, эрх, үүрэг, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон бусад зардал, төлбөр тооцооны нөхцөл зэргийг тусгасан байна.

12.5.Олон нийтийн ажлыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

12.6.Олон нийтийн ажлын нэг цагийн хөлс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байх бөгөөд нэг удаагийн үргэлжлэх хугацаа 10-аас илүүгүй өдөр байна.

12.7.Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллага олон нийтийн ажилд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийн сан үүсгэж, урамшуулах зорилгоор сурталчлан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл.Дагалдан ажилтныг дэмжих

13.1.Дагалдан ажилтныг дэмжих арга хэмжээг ажил олгогчтой байгуулсан гэрээнд заасан хугацааны дагуу ажлын байранд дасан зохицох, ур чадвар эзэмших, тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд шилжих үйл явцыг дэмжих зорилготойгоор хэрэгжүүлнэ.

13.2.Дагалдан ажилтныг дэмжих арга хэмжээнд ажилгүй иргэн болон их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллага нь ажил олгогчтой хамтран хэрэгжүүлнэ.

13.3.Дагалдан ажилтныг ажиллуулж буй ажил олгогчийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага бүртгэж, гэрээ байгуулан хамтарч ажиллана.

13.4.Ажил олгогч дагалдан ажилтныг 6 сар ажиллуулсны дараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх 6 сарын цалингийн дэмжлэгийг авч болно.

13.5.Цалингийн дэмжлэгийн эрх нь ажил олгогчийн гэрээний үүргийг биелүүлсэн байдлыг үндэслэн ажил эхэлснээс хойш 6 сарын дараа үүснэ.

13.6.Дагалдан ажилтанд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулан зохион байгуулж, сургалтын зардлыг ажил олгогчийн хүсэлтийг үндэслэн Ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлж болно.

13.7.Дагалдан ажилтныг ажиллуулахтай холбоотой бусад зардлыг ажил олгогч өөрөө бүрэн хариуцна.

13.8.Дагалдан ажилтныг ажлын байранд чадамжид суурилсан хөгжлийн төлөвлөгөөний дагуу сургах бөгөөд энэхүү төлөвлөгөөг ажил олгогч, сургалтын байгууллагын төлөөлөл хамтран боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавина.

13.9.Олон дагалдан ажилтныг үр дүнтэй сургаж, тогтвортой ажиллуулсан ажил олгогчийг урамшуулах бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд татварын хөнгөлөлт, нийгмийн хариуцлагын урамшуулал, олон нийтийн мэдээлэлд таниулах зэрэг хэлбэр байж болно.

13.10.Дагалдан ажилтнаас сургалтын явц, ажлын орчин, удирдлага, дасан зохицох байдал зэргийг үнэлэх санал асуулга авч, үр дүнг хөтөлбөрийн чанар сайжруулахад ашиглана.

13.11.Дагалдан ажилтныг хүлээн авах ажил олгогчдын жагсаалтыг ил тод, нээлттэй байлгаж, иргэд өөрсдийн сонголтоор ажил олгогчид хандах боломжийг бүрдүүлнэ.

14 дүгээр зүйл. Аж ахуй эрхлэгчийг дэмжих

14.1. Аж ахуй эрхлэгчийг дэмжих арга хэмжээг гарааны болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл, хоршоо байгуулах хүсэлтэй иргэнд үйл ажиллагаа эхлэх, хөгжүүлэх сургалт зөвлөгөө өгөх, бичил зээл олгох, зах зээлд нэвтрэх боломжоор хангахыг багтаан ойлгоно.

14.2. 14.1 дэх арга хэмжээ нь аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хэлбэртэй байж болно. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хамрах хүрээнд 50 ба түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоог эзэмшдэг, эсхүл төлөөлөн удирдах зөвлөл, тэргүүлэгчдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүд бүрдүүлдэг аж ахуйн нэгж, гишүүдийн 51-ээс доошгүй хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлдэг нөхөрлөл, хоршоо болон хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйг багтаан ойлгоно.

14.2. 14.1 дэх арга хэмжээг эмэгтэйчүүдэд зориулсан байдлаар төрөлжүүлэн хэрэгжүүлж болно. Энэхүү дэмжлэгт хамрагдах аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хамрах хүрээнд 50 ба түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоог эзэмшдэг, эсхүл төлөөлөн удирдах зөвлөл, тэргүүлэгчдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүд бүрдүүлдэг аж ахуйн нэгж, гишүүдийн 51-ээс доошгүй хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлдэг нөхөрлөл, хоршоо болон хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйг багтаан ойлгоно.

14.2. 14.1 дэх арга хэмжээний хүрээнд аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдэд чиглэсэн тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж болно. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдэд аж ахуйн нэгжийн 50 ба түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоог эзэмшдэг, эсхүл төлөөлөн удирдах зөвлөл, тэргүүлэгчдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүд бүрдүүлдэг аж ахуйн нэгж, нөхөрлөл хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлдэг, өрхийн аж ахуй эрхэлдэг хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйг багтаан ойлгоно.

14.3. Аж ахуй эрхлэгчийг дэмжих арга хэмжээг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

14.3.1. аж ахуй эрхлэх ур чадварыг үнэлэх, сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээ;

14.3.2. бичил зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх;

14.3.3. үйл ажиллагааны дэмжлэг олгох.

15 дугаар зүйл. Аж ахуй эрхлэх ур чадварыг үнэлэх, сургалт, бизнесийн зөвлөгөө өгөх

15.1. Гарааны болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэнийг хөдөлмөрийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага бүртгэн, мэргэжлийн байгууллагатай хамтран аж ахуй эрхлэх ур чадварын үнэлгээнд хамруулна.

15.2.Үнэлгээнд хамрагдсан аж ахуй эрхлэгчийг бизнес санаа хөгжүүлэх, бизнес хөгжлийн сургалт, бизнес зөвлөх үйлчилгээнд хамруулна.

15.3.Хөдөлмөрийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, үр дүнгийн гүйцэтгэлд үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт олгоно.

15.4.Аж ахуй эрхлэх ур чадварын үнэлгээний аргачлал, сургалт зөвлөгөөний жишиг зардал тарифыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 2 жил тутамд тогтооно.

15.5.Бизнесийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, түншлэлийн харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэн туршлага уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.

16 дугаар зүйл.Бичил зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх

16.1.Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эхлүүлэх, үйл ажиллагаа өргөжүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажлын байр хадгалах, шинээр бий болгоход 50 хүртэлх сая төгрөгийн бичил зээлийг арилжааны банкаар дамжуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоно.

16.2.Бичил зээлийн хүүгийн хэмжээ, арилжааны банк сонгон шалгаруулах удирдамжийг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

16.3.Бичил зээлийн хүүгийн хэмжээ нь арилжааны банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна.

16.4.Аж ахуй эрхлэгч асрахуйн үйлчилгээний байгууллага ажиллуулах, байгаль орчинд ээлтэй, экспортын зориулалттай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл худалдан авахад зориулж бичил зээл авсан бол зээлийн хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлнө.

16.5.Бичил зээл авах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжид банкны шаардлага хангахад барьцаа хөрөнгийн дэмжлэг шаардлагатай тохиолдолд батлан даалт гаргаж болно.

16.6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бичил зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сангийн хөрөнгийг бүртгэх, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

17 дугаар зүйл.Ажил олгогчид үйл ажиллагааны дэмжлэг олгох

17.1.Үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, өргөжүүлэх, бараа бүтээгдэхүүн хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэх, борлуулах, сүлжээ үүсгэх, богино хугацааны эргэлтийн хөрөнгө, түрээсийн дэмжлэгийг үзүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил олгогчид санхүүгийн дэмжлэгийг олгоно.

17.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зорилтот бүлгийн хүн амыг ажлын байраар хангасан ажил олгогчид дараах урамшууллыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоно.

17.2.1.байнгын ажлын байраар хангаж, тогтвортой ажиллуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг хэсэгчлэн олгоно.

17.2.2.үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангасан тохиолдолд 3 сарын дадлагын хугацааны сургалтын зардлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тогтоосон зардлын жишиг хэмжээгээр нөхөн олгоно.

17.3.Шинэлэг гарааны бизнес эрхлэхийг дэмжих төсөл, хөтөлбөрийг Засгийн газар баталж болно.

17.4.Аж ахуйн нэгж дэх хөдөлмөрийн харилцааны төлөвшлийг дэмжихэд ажил олгогчийн хүсэлт, эрэлт хэрэгцээний дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн харилцааны сургалтын үйлчилгээг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэшсэн зөвлөх, мэргэжлийн байгууллагатай хамтран гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

18 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор энэ хуулийн 5.1-т заасан үйл ажиллагаанаас гадна хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэлбэрт нийцүүлэн дараах төрлийн үйлчилгээг цогц үнэлгээнд үндэслэн цогцоор болон хэсэгчлэн үзүүлж болно.

18.1.1.хөдөлмөрийн нөхөн сэргээлтийн үйлчилгээ;

18.1.2.халамжийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ;

18.1.3.хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ буюу ажлын байранд дадлагажуулах үйлчилгээнд хамруулах

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦОО

19 дүгээр зүйл.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцооны зорилго, ашиглалт

19.1.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцооны зорилго нь хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээлэл цуглуулж, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт, мэргэжил, ур чадварын хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, чиг хандлагын талаарх бодитой, хүртээмжтэй мэдээллээр бодлого боловсруулагч, ажил олгогч, иргэн, боловсрол, сургалтын байгууллагыг цахим болон цахим бусаар түргэн шуурхай хангахад оршино.

19.2.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийг дараах зориулалтаар ашиглана.

19.2.1.зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх;

19.2.2.хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, өөрчлөлт, чиг хандлагыг ажиглах, дүн шинжилгээ хийх;

19.2.3.үндэсний мэргэшлийн тогтолцоо, мэргэжлийн стандартыг шинэчлэх;

19.2.4.боловсрол, сургалтын байгууллагын элсэлтийг төлөвлөх, сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх;

19.2.5.иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, карьер төлөвлөлтийн зөвлөгөө өгөх;

19.2.6.ажилгүй иргэн, ажил олгогчийг хэрэгцээтэй мэдээллээр хангах;

19.2.7.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг бусад салбарын бодлоготой уялдуулах, холбох, хамтран ажиллах;

19.2.8.бусад мэдээллийн зориулалтаар ашиглах.

20 дугаар зүйл.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцооны бүтэц

20.1.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцоо нь мэдээлэл цуглуулах сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан, мэдээлэл

боловсруулах, дүн шинжилгээ хийх аргачлал, программ хангамж болон техник хангамж, мэдээлэл түгээх суваг, мэдээллийн эх үүсвэрээс бүрдэнэ.

21 дүгээр зүйл.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан

21.1.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан нь хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, чиг хандлагын талаарх мэдээлэл, үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандарт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтны мэдээллийг агуулна.

21.2.Үндэсний статистикийн хороо, нийгмийн даатгал, боловсрол, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллага нь хариуцсан чиг үүргийн хүрээнд хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцоонд хэрэгцээтэй мэдээллийг гаргаж өгч болно.

21.3.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн сан төрийн нэгдсэн мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцож болно.

21.4.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцоо нь хувийн хэвшлийн ижил төстэй мэдээллийн эх үүсвэртэй харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллаж болно.

21.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн эх сурвалж нь иргэн, хуулийн этгээд байна.

21.5.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн түүх үүсгэсэн байна.

21.5.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хувь хүний нууцыг хадгална.

21.6.Ажил олгогч болон төрийн байгууллага нь ажиллах хүч болон орон тооны талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагад тухай бүр гарган өгч мэдээллийг шинэчилнэ.

21.7.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн маягтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйл ажиллагааны бусад маягтыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

22 дугаар зүйл.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцоог хариуцах байгууллага

22.1.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн тогтолцооны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээ, мэдээллийг нэгтгэх, ашиглах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг түгээх чиг үүргийг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

22.2.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн тогтолцооны мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны аюулгүй байдал, хамгаалалтын журам, стандартыг тогтоох, хяналт тавих, программ болон техник хангамжийг хөгжүүлэх, төрийн нэгдсэн мэдээллийн сантай хамтран ажиллах, мэдээллийн ил тод байдлыг хангах чиг үүргийг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ**

23 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

23.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сантай байна.

24 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

24.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 24.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- 24.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- 24.1.3.орон нутгийн дэд сангийн хөрөнгө;
- 24.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;
- 24.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;
- 24.1.6.Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;
- 24.1.7.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү;
- 24.1.8.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;
- 24.1.9.ажилгүйдлийн даатгалын сангийн орлого;
- 24.1.10.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэнээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;
- 24.1.11.бичил зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;
- 24.1.12.Ашигт малтмалын тухай хуулийн 43.1.1-д зааснаас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд ногдуулсан ажлын байрны төлбөр;
- 24.1.13.бусад эх үүсвэр.

25 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт

25.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:

- 25.1.1.энэ хуулийн 5.1.1-5.1.2-д заасан үйлчилгээ, арга хэмжээ;
- 25.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, үйл ажиллагаанд шаардагдах техник тоног төхөөрөмж, программ хангамжийг шинэчлэх, сайжруулах, аюулгүй байдлыг хангах;
- 25.1.3.хөдөлмөрийн салбарын ажилтны чадавхыг бэхжүүлэх сургалт, давтан сургалт зохион байгуулах, ажлын гүйцэтгэл үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох;
- 25.1.4.үндэсний, салбарын болон орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээний ажил хийх;
- 25.1.5.хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаар сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэж хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх;
- 25.1.6.мэргэшлийн түвшний үндэсний ангилал, ажил мэргэжлийн стандарт боловсруулах, ашиглах үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- 25.1.7.хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх;

25.1.8.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт, чанар, үр дүнд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

25.1.9.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал, зөвлөлийн гишүүний урамшуулал олгох;

25.1.10.Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3-т заасан арга хэмжээг санхүүжүүлэх;

25.1.11.Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх.

25.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагаанд хамаарах энэ хуулийн 25.1-д заасан үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

25.3.Энэ хуулийн 24.1.5-д заасан төлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.

25.4.Энэ хуулийн 24.1.6-д заасан төлбөрийг ахмад настай хүний хөдөлмөр эрхлэлт, хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.

25.5.Ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэн болон Аж ахуйн нэгж байгууллагын ажилтныг сургах, чадавхжуулах мэргэжлийн сургалтын зардлыг ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

26 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв

26.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилна.

26.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тухайн жилд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг улсын хөгжлийн бодлогын зорилт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдал, ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харгалзан Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал батална.

26.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсвийн хуваарийг тухайн оны улсын төсөв батлагдснаас хойш 21 хоногийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг хуваарилахдаа үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн аргачлалыг ашиглана.

27 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлан, тэнцэл гаргах

27.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дараах хугацаанд гаргаж хүргүүлнэ:

27.1.1.улирлын тайланг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 15-ны өдрийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

27.1.2.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улирлын нэгдсэн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад.

28 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн бүртгэл, тайлангийн маягт

28.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

29 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо

29.1.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтан, хөдөлмөрийн судалгаа, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн хувийн байгууллагаас бүрдэнэ.

30 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл

30.1.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь хамтын удирдлага хэрэгжүүлдэг эрдэмтэн судлаачид, төрийн байгууллага, ажилтан, ажил олгогчийн төлөөллөөс бүрдсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогын талаар зөвлөлдөх орон тооны бус байгууллага байна.

30.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

30.3.Төрийн байгууллагын төлөөлөл нь эдийн засгийн хөгжил, боловсрол, төсөв санхүү, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

30.4.Ажилтан болон ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагаас тус бүр 5 хүний төлөөлөл багтана.

30.5.Эрдэмтэн, судлаачдын төлөөлөл нь эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн 5 хүнээс бүрдэнэ.

30.6.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дарга нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

30.7.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.7.1.хөдөлмөр эрхлэлтийн болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомж, үйл ажиллагааг боловсронгуй болгох зөвлөмж өгөх;

30.7.2.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, стратеги, хөтөлбөрийн төслийг хэлэлцэн санал, зөвлөмж өгөх;

30.7.3.энэ хуулийн 5.2.7, 5.3.5-д заасан туршилтын болон бусад үйлчилгээ, арга хэмжээг хэлэлцэн батлах;

30.7.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, уг үйл ажиллагааны үр дүнд хийсэн хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

31 дүгээр зүйл.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

31.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

31.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах, зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

31.1.2.хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах;

31.1.3.хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах;

31.1.4.хөдөлмөрийн зах зээлийн их өгөгдлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөгжүүлэх;

31.1.5.хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон хөдөлмөрийн хувийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хууль тогтоомжийн хүрээнд бодлогын удирдамж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, салбарын болон салбар дундын зохицуулалт хийх, хяналт тавих;

31.1.6.хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандарт, хэм хэмжээг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

31.1.7.Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн бодлогын зөвлөмж, санал, дүгнэлтийн талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;

31.1.8.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт хийх зарцуулалтад хяналт тавих,

31.1.9.иргэдийн амьжиргааг дээшлүүлэх нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн байгууллагын хамтын үйл ажиллагааны уялдааг бодлого зохицуулалтаар хангах;

31.1.10.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах үйл ажиллагааны тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, уг үйл ажиллагааны үр дүнд хийсэн хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

31.1.11.хууль тогтоомжид заасан бусад эрх.

32 дугаар зүйл.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

32.1.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах хүрээнд дараах чиг үүрэг гүйцэтгэнэ:

32.1.1.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлын судалгаа гаргах, хэтийн тооцоо боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах;

32.1.2.хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэл, мэдээллийн системд холбогдсон байгууллагыг программ хангамж болон мэргэжил, арга зүй, техникийн удирдлагаар хангаж, мэдээллийн нэгдмэл орчинд үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

32.1.3.хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон хөдөлмөрийн хувийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйлчилгээ, арга хэмжээний зардал, чанар, хүртээмжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгөх;

32.1.4.хөдөлмөрийн хувийн байгууллагатай гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгох;

32.1.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, өр авлагын барагдуулалтад хяналт тавих, шийдвэрлүүлэх;

32.1.6.хөдөлмөрийн зах зээлийн богино, дунд, урт хугацааны эрэлт, нийлүүлтийн тооцоо, судалгаа, мэдээлэлд тулгуурлан ажиллах хүчнийг бэлтгэх, хэрэгцээг хангах;

32.1.7.шинэ технологи, инноваци, бүтээмжийг нэмэгдүүлэх санал дүгнэлт боловсруулж, мэдээллээр хангах;

32.1.8.хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, Засгийн газар хоорондын гэрээ хэлцлийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах;

32.1.9.гадаадад суралцаж, ажиллаж амьдарч байгаа монгол иргэдийг эх орондоо эргэн ирж, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

32.1.10.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

33 дугаар зүйл.Хөдөлмөрийн судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага

33.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь дараах чиглэлээр тогтмол болон захиалгат судалгаа, шинжилгээ, сургалт, хөгжлийн ажил хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулж, мэдээллээр хангана:

33.1.1.макро эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөлөл, үнэлгээний судалгаа, шинжилгээ;

33.1.2.эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, мэргэшил тус бүрээр ажиллах хүчний богино, дунд, урт хугацааны судалгаа, хэтийн төлөвийн тооцоолол, таамаглал;

33.1.3.хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний судалгаа, шинжилгээ;

33.1.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөөний судалгаа, шинжилгээ;

33.1.5.хөдөлмөрийн зах зээлийн их өгөгдлийн мэдээллийн дүн шинжилгээ;

33.2.Хөдөлмөрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна;

33.3.Судалгаа, шинжилгээний асуудлаар байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад шаардлагатай мэдээлэл, тооцоо, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авна.

34 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага

34.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж, хөдөлмөр болон аж ахуй эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, сурталчлах;

34.1.2.харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд ажилгүй иргэн, ажил хайгч болон ажлын байрны захиалгын бүртгэл, мэдээллийн сан үүсгэх;

34.1.3.харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах;

34.1.4.хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцооны мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг үнэн зөв оруулах;

34.1.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

34.1.6.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4, Ашигт малтмалын тухай хуулийн 43.2-т тус тус заасан төлбөрийг төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

34.1.7.харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

34.1.8.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

34.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь улсын төсвөөс санхүүжнэ.

35 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

35.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.орон нутгийн онцлог хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах;

35.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах;

35.1.3.бүс, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, орон нутагт шаардлагатай ажил мэргэжлийн чиглэлийг тодорхойлж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

35.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

36 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх, үүрэг

36.1.Аймаг, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны талаар орон нутгийн хөгжлийн бодлогод тодорхой зорилтуудыг тусган хэрэгжүүлэх, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн хөрөнгийг тухайн орон нутгийн төсөвт тусгуулах талаар жил бүр санал боловсруулж батлуулах, батлагдсан хөрөнгийг хуваарилах;

36.1.2.орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;

36.1.3.хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

36.1.4.орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүүг судлах, холбогдох арга хэмжээ авах ажлыг 2 жил тутам зохион байгуулах;

36.1.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд уялдуулан зохион байгуулах, хянах, үнэлэх;

36.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

36.2.Аймаг, дүүргийн Засаг дарга хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж, сум, хорооны Засаг дарга хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтныг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.

37 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага

37.1.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл түүний эрх олгосон байгууллагаас эрх авсан төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага байна.

37.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж болно.

37.3.Зохих мэдлэг, ур чадвар эзэмшсэн үйлчилгээний ажилтантай, стандартад нийцсэн үйлчилгээний танхим, тоног төхөөрөмжтэй, иргэнд цахим орчинд мэдээлэл авах, ажил хайх боломжийг бүрдүүлсэн байх нийтлэг шаардлагыг хангана.

37.4.Хүн амын бүлэг, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг төрөлжүүлэн хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

37.5.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагагаас баталсан лого, брэндингийг ашиглаж үйл ажиллагаа явуулж болно.

37.6.Хоёр ба түүнээс дээш тооны хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага энэ хуулийн 37.5-д заасан тусгай лого, брэндингийг ашиглаж, хамтран ажиллаж болно.

37.7.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага хууль тогтоомж, гэрээнд заасан бол энэ хуулийн 5.1.2-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг үзүүлж болно.

38 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын бүртгэл, үйлчилгээний төлбөр, санхүүжилт

38.1.Хөдөлмөрийн хувийн байгууллагыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл түүний эрх олгосон байгууллага бүртгэж, цахим мэдээллийн нэгдсэн санд холбоно.

38.2.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүнийг бүртгэх, гэрээ байгуулах, санхүүжилт олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.3.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагад энэ хуулийн 38.2-т заасан журам, гэрээний дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт олгоно.

38.4.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэнээс шууд болон шууд бус хэлбэрээр төлбөр авахыг хориглоно.

38.5.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага цагийн болон өдрийн ажилд зуучлах үйлчилгээг үзүүлж болно.

38.6.Цагийн болон өдрийн ажилд зуучлах үйлчилгээнд төрөөс санхүүжилт олгохгүй.

39 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаан дахь аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, оролцоо

39.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй байна:

39.1.1.ажилтнуудыг бөөнөөр халах, цомхотгох тохиолдолд энэ тухай Хөдөлмөрийн тухай хуулийн 81.6-д заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад нэг сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэнэ.

39.1.2.ажлын байрны захиалга, ажиллах хүчний хэрэгцээ, ур чадварын шаардлагын талаарх мэдээллийг хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны мэдээллийн тогтолцооны мэдээллийн санд тогтмол мэдээллэх үүрэгтэй.

39.1.3.ажлын сул орон тоонд хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас санал болгосон хүнийг ажилд авсан бол шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн байгууллагад эргэн мэдэгдэнэ.

39.1.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 144, 145 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан, мэдээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад улирал тутам гаргаж ирүүлнэ.

39.1.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ.

39.1.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

40 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаан дахь иргэний эрх, үүрэг, оролцоо

40.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч иргэн энэ хуульд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна:

40.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах хүсэлтээ хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтанд гаргаж бүртгүүлэх, бүртгүүлсний дараа холбогдох журмын дагуу идэвхтэй харилцаж, хамтран ажиллах;

40.1.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуульд заасны дагуу олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, ажилтанд заасан хугацаанд ирүүлэх;

40.1.3.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай шаардлагатай бол хувийн төлөвлөгөө боловсруулж ажиллах, санал болгосон ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнээс сонголт хийх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

41 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

41.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина:

41.1.1.Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд;

41.1.2.олон нийтийн хяналтыг иргэний нийгмийн байгууллага.

41.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД

42 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

42.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсвэл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.3.Энэ хуулийг зөрчсөн үйлдлийн улмаас бусдад хохирол учруулсан бол Иргэний хуульд заасны дагуу буруутай этгээд уг хохирлыг нөхөн төлнө.

43 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

43.1.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ